



Хууль сахиулахуй

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

THE CURRENT STATUS OF ENVIRONMENTAL CRIME AND VIOLATIONS AND SOME ISSUES TO BE CONSIDERED IN PREVENTIVE WORK

Б.Баянмөнх

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа

Bayanmunkh B.

Doctor (Ph.D.), Associate Professor, Police Colonel Center for Crime, Police, and Internal Military Studies, Research Institute of the University of Internal Affairs, Mongolia

С.Буяндэлгэр

Цагдаа судлалын магистрант, цагдаагийн дэслэгч

Buyandelger S.

Master's student in Police Studies Police lieutenant

*Хариуцлагатай зохиогч: b.bayadaa2007@gmail.com

Хураангуй. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь манай орны байгалийн нөөцийг доройтуулж, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулснаар хүн амын эрүүл мэнд, амьдрах орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, ирээдүй үеийн амьдралд нөхөж баршгүй хохирол учруулдаг нийгмийн сөрөг үзэгдэл учраас бид энэхүү сэдвийг сонгон авч, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харгалзан бичсэн болно.

Бид энэхүү өгүүллийг бичихдээ бид хөдөө, орон нутгийн цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа экологийн цагдаагийн байцаагч нараас анкет асуулгын аргаар судалгаа авч, дүн шинжилгээ хийх, хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актуудад барим бичгийн шинжилгээ хийх аргыг, алба хаагч нартай фокус ярилцлагын аргыг тус тус ашиглалаа. Түүнчлэн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд ашиглаж буй Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн актууд, Экологийн цагдаагийн албаны сүүлийн 4 жилийн тайлан, статистик тоо мэдээ, экологийн байцаагч нараас авсан судалгааны тайлан, гадаадын зарим орны нэвтрүүлсэн туршлага, эрдэмтэн судлаачдын гаргасан ном бүтээлүүдийг ашиглалаа.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гарч байгаа өнөөгийн төлөв байдал болон урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж ажил, арга хэмжээ, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар экологийн 24 байцаагчаас авсан судалгаа, түүний үр дүн, гадаадын зарим оронд нэвтрүүлсэн туршлагыг үндэслэн гаргасан дүгнэлт, саналын талаар товч авч үзсэн болно.

Abstract. Environmental crimes and violations are a negative social phenomenon that degrades the natural resources of our country and disrupts the ecological balance, has a serious negative impact on the health and living environment of the population, and causes irreparable damage to the sustainable economic development of the country and the lives of future generations. Therefore, we have chosen this topic and written it considering the need to improve the effectiveness of preventive work.

In writing this article, we used the method of conducting a survey and analysis of ecological police inspectors working in rural and local police organizations using questionnaires, document analysis of laws and related legal acts in the field of combating environmental crimes and violations, and focus group interviews with officers. In addition, the Mongolian laws and legal acts used to combat environmental crimes and violations, the last 4 years of the Ecological

Police Service's reports, statistical data, research reports from ecological inspectors, the experience introduced in some foreign countries, and books published by scholars.

This article briefly discusses the current state of environmental crimes and violations in Mongolia, the work and measures being taken to prevent them, the difficulties encountered, and the solutions, based on the results of a survey conducted by 24 ecological inspectors, as well as the conclusions and suggestions drawn from the experiences introduced in some foreign countries.

Түлхүүр үг. Хүрээлэн буй орчны эсрэг зөрчил, экологийн байцаагч, урьдчилан сэргийлэх ажил, туршлага

Keywords: Environmental violations, ecological inspectors, preventive work, experience

Удиртгал. Монгол Улс нь өргөн уудам нутаг, ан амьтан, ойн салбар, усны баялагтай орон бөгөөд эдгээр нь улс орны байгалийн капиталын чухал хэсэг боловч эдгээр нөөцөд суурилсан янз бүрийн хууль бус болон зохисгүй үйл ажиллагаанууд (хууль бус мод бэлтгэл, алт олборлолт, хууль бус ан агнуур, бохирдуулагч үйлдвэрлэл, газрын эвдрэл) нь байгаль орчны доройтол болон нутгийн иргэдийн амжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт хууль бусаар ан агнах, ой хээрийн түймэр үүсгэх, газрын хөрсийг гэмтээх, ургамал, ой мод болон ашигт малтмалыг хууль бусаар ашиглах зэрэг хууль бус үйлдлүүдийг хамруулан авч үздэг.

Монгол Улсын хэмжээнд 2022 оноос 2025 оны эхний 8 сар хүртэлх хугацаанд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 8143 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасанаас 4180 нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна. Энэ нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт гомдол, мэдээллийн 51.3%-ийг эзэлж байгаа, түүнчлэн сүүлийн 4 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил жил бүр өссөн статистик тоо мэдээ байгаа нь урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй, зохих хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа нь энэхүү сэдвийг сонгон авах үндэслэл болсон болно.

Энэхүү өгүүллийн шинэлэг тал нь эрдэмтэн судлаачид болон иргэдийн дунд байгаа нэр томъёоны зөрүүтэй ойлголтын талаар судлаачийн үүднээс хийсэн тайлбар хийснээр тодорхойлогдож байна. Харин хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр экологийн байцаагч нараас гаргасан санал болон гадаадын зарим оронд нэвтрүүлэн тодорхой үр дүнд хүрсэн туршлагууд дээр үндэслэн санал боловсруулсан нь энэхүү өгүүллийн практик ач холбогдлыг тодорхойлж байна.

Байгаль орчны эсрэг зөрчил гаралтын өнөөгийн төлөв байдалд шинжилгээ хийж, жил бүр өсч байгаа шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, экологийн байцаагч нар энэхүү асуудалд хэрхэн хандаж байгаа судалгаагаар гарган дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үндэслэл бүхий санал боловсруулах нь энэхүү өгүүллийн зорилго оршиж байна.

Үндсэн хэсэг. Манай улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж олборлолт, ашиглалтын технологийн онцлог, дэд бүтцийн байгууламжийг харилцан уялдаатай төлөвлөөгүйгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил хоцрогдож, хүрээлэн байгаа орчинд ихээхэн хохирол учрах болсон. Хүний буруутай үйл ажиллагааны улмаас сүүлийн жилүүдэд манай орны өндөр уулын мөнх цас, мөсөн голын усны нөөц багасаж, 391 нуур тойром, 344 гол горхи, 760 булаг шанд ширгэж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн Монгол Улсын нийт газар нутгийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай цөлжилтөд өртөж, томоохон төв суурин газруудын ундны усны нөөц шавхагдах зэрэг бодит аюул тулгарч байгаа талаар мэргэжлийн байгууллагууд судалгаа гаргасан. (цагдаагийн хурандаа Т.Баатар: хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг,



Австралийн Элчин Т.Баатар



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠤᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

зөрчилтэй тэмцэх ажил зөвхөн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулснаар үр дүнд хүрэхгүй, n.d.)

Байгаль орчныг хамгаалах гэдэг ойлголтыг хууль зүйн талаас нь тодорхойлсон эрх зүйн дифинитив хэм хэмжээг зарим улсад хуулиар тогтоосон байдаг¹. Монгол Улсын хувьд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д "байгаль орчин" гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна, мөн зүйлийн 3.7-д "байгаль орчныг хамгаалах" гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна" (Байгаль орчныг хамгаалах тухай, n.d.) гэж тус тус хуульчилсан.

Орчин үеийн техник технологийн үсрэнгүй хөгжил, түүнийг дагасан нийгэм, эдийн засгийн хөгжил нь хүний эрүүл, аюулгүй амьдрах эрхэд сөргөөр нөлөөлж, хүрээлэн буй орчны доройтолд хүргэн экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Үүнээс улбаалан хүн төрөлхтний өмнө нэн түрүүнд тулгамдаж буй асуудал бол хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах асуудал болж байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил болон байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гэж УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид 2 янзаар ярьж, хэлж, бичиж байгаа нь нэр томъёоны хувьд зөрүүтэй

ойлголт одоог хүртэл байгааг харуулж байгаа бөгөөд иргэдийн дунд буруу ойлголт төрүүлэх төдийгүй нэр томъёоны хувьд тулгамдсан асуудал гэж үзэж болохоор байна.

Хууль зүйн шинжлэх ухаанд байгаль орчныг хамгаалах асуудлыг хуульчилсан хэм хэмжээ тогтоосон хүрээнд түүний ойлголт, агуулгыг хязгаарладаггүй онцлог бүхий өргөн агуулгатай ухагдахуун юм. Учир нь хуулиар тогтоосон байгаль орчин, түүний объектыг хамгаалахаас гадна хүрээлэн буй орчинд оршин амьдрах хүнийг хамгаалах гэсэн өргөн цар хүрээгээр авч үздэг шинжлэх ухааны ойлголт билээ.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил"-ийн нэг дэд хэсэг бөгөөд илүү нарийвчилсан, байгалийн нөөцөд чиглэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл "Хүрээлэн буй орчны эсрэг" гэдэг нь илүү өргөн хүрээтэй, хүний оршин тогтнох таатай нөхцөлийг хамгаалах зорилготой цогц ойлголт юм.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь хүрээлэн буй орчныг бүрдүүлэгч байгалийн, нийгмийн болон хүний орчны аюулгүй байдлыг зөрчиж, бохирдуулж, экосистем болон хүний амьдралд сөрөг нөлөө үзүүлдэг аливаа хууль бус үйлдэл юм. Өөрөөр хэлбэл энэ нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд байгалийн орчин дээр нэмээд хүний амьдрах орчныг хамааруулдаг юм.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь байгалийн баялаг, нөөц, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох газар, ус, ой, ан амьтан, агаар зэрэгт шууд халдсан, устгасан, бохирдуулсан үйлдэл юм. Энэ нь илүү нарийн хүрээтэй, байгаль руу чиглэсэн үйлдэл юм.

Үзүүлэлт	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил
Ойлголтын цар хүрээ	Агаар, дуу чимээ, хог, химийн бодис, цацраг бохирдол үүсгэх, зөвшөөрөлгүй хаягдал гаргах.	Хууль бус ан агнуур, мод бэлтгэл, ашигт малтмал олборлолт, ус бохирдуулах.
Зорилтот объект	Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, экосистемийн тэнцвэрт байдал.	Байгалийн баялаг (ой, ус, газар, амьтан, ургамал гэх мэт).

Үйлдлийн хэлбэр	Агаар, дуу чимээ, хог, химийн бодис, цацраг бохирдол үүсгэх, зөвшөөрөлгүй хаягдал гаргах.	Хууль бус ан агнуур, мод бэлтгэл, ашигт малтмал олборлолт, ус бохирдуулах.
Нөлөөллийн цар хүрээ	Хүний эрүүл мэнд, амьдрах орчны аюулгүй байдалд нөлөөлдөг.	Байгалийн тэнцвэрт байдал, биологийн төрөл зүйл, экосистемийн бүтцийг устгадаг.
Хууль зүйн зүйлчлэл	Эрүүгийн хуулийн 24-р бүлэг “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг”	7 дугаар бүлэг. Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил



Дэвсгэрсэн Ойлогт нь хоёулаа

Дээрх хоёр ойлголт нь хоёулаа экологийн аюулгүй байдал, байгалийн хамгаалалт, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой ойлголтууд боловч хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь илүү өргөн хүрээтэй, хүний эрүүл мэнд, аж ахуйн үйл ажиллагааны орчныг хамардаг бол байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь илүү нарийвчилсан, байгалийн нөөцөд чиглэсэн тодорхой төрлийн зөрчил юм байна. Эндээс бид байгаль орчны эсрэг зөрчлийн талаар нарийвчилан авч үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; хэмээн заасан байдаг”, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”, 38 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах” (Монгол Улсын Үндсэн хууль, *n.d.*) гэсэн зүйл заалтуудаар байгаль хамгаалахтай холбоотой суурь зохицуулалт тодорхойлогдож байна.

Бид энэхүү өгүүлэлээ бичихдээ Экологийн цагдаагийн албаны хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчлийн статистик

тоо мэдээ, төв, орон нутгийн цагдаагийн газрын экологийн байцаагч нараас авсан судалгаа болон гадаадын зарим орны байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн туршлагаар агуулгын хүрээ хязгаарлалтаа тогтоосон болно.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгалийн объект (газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар)-ыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэх агуулгаар хуульчилсан.¹

Байгаль орчны эсрэг зөрчил гэдэг нь хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг үр дагавар учруулахуйц, хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Энэ нь байгаль хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, экосистемийн тэнцвэрийг хадгалахтай холбоотой харилцааг зөрчиж, төрийн хууль ёсны хамгаалал дор байгаа нөөц баялагт халдах явдал юм.

Байгаль орчны эсрэг зөрчил нь байгаль хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчиж, хүрээлэн буй орчин, түүний бүрдэл хэсэгт (агаар, ус, хөрс, ой, амьтан, ургамал, ашигт малтмал г.м.) хохирол учруулдаг эсвэл хохирол учруулж болзошгүй хууль бус үйлдэл, эс үйлдэхүй юм.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь зөвхөн хууль сахиулах байгууллагын ажил биш, төр, иргэн, байгууллага, олон нийтийн

¹ Байгаль орчны салбарын хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг арилгах дүн шинжилгээ хийх, салбарын хуулиудад

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах судалгаа. -УБ., 2023. 32 дахь тал



Хууль сахиулахуй

хамтын ажиллагаанд суурилдаг. Харин хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь байгаль орчин, түүний баялаг (*ус, ой, ан амьтан, газар, ашигт малтмал гэх мэт*)-ийг хууль бус ашиглалт, сүйтгэл, бохирдлоос хамгаалах, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хууль дээдлэх ухамсар, зөв дадал төлөвшүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг эрт илрүүлэн таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх иж бүрэн үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь эрүүгийн эрх зүйн урьдчилан сэргийлэлт, зөрчлийн эрх зүйн урьдчилан сэргийлэлт, нийгэм-сэтгэл зүйн урьдчилан сэргийлэлт гэсэн олон талт шинжтэй.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь төр, орон нутгийн байгууллага, иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан дараах 4 үндсэн чиглэлээр хэрэгжиж байна.

1. Хууль, бодлогын түвшний урьдчилан сэргийлэлт

Байгаль орчныг хамгаалах тухай “Зөрчлийн тухай (*Зөрчлийн тухай, n.d.*)”, “Ойн тухай (Ойн тухай, n.d.)”, “Газрын тухай (*Газрын тухай, n.d.*)” зэрэг хуулиудын хэрэгжилтэд тулгуурлан урьдчилан сэргийлэх зохицуулалт хийгдэж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БО,УААЯ), Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Байгаль орчны мэргэжлийн хяналтын газар хамтран “Ногоон хамгаалал-2025”, “Хууль бус олборлолттой тэмцэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж байна.

Байгаль орчны хяналтын чиглэлээр 2025 оны 8 дугаар сард 97 гомдол, мэдээллийг шалгаж 81 гомдол мэдээллийг шийдвэрлэж, 5 гомдолд зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан байна. Нэг хэргийг харьяалах чиглэлийн хяналтад, гэмт хэргийн шинжтэй 5 хэргийг цагдаагийн байгууллагад шилжүүлжээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нийт 84 иргэн, аж ахуйн нэгжид 50.350.0 мянган төгрөгийн торгууль, 50 иргэн, аж ахуйн

нэгжид 67.912.7 мянган төгрөгийн нөхөн төлбөр ноогдуулсан байна.

Гомдол мэдээллээс үзэхэд зохих зөвшөөрөлгүй амьтан агнасан, амьтны гаралтай түүхий эд худалдсан, цооног гаргасан, газрын хэвлийд дур мэдэн халдсан, ашигт малтмал эрэн хайсан, байгалийн ургамал түүж бэлтгэсэн, өнгөт чулуу түүсэн, хүрээлэн байгаа орчин бохирдуулсан, хог хаягдлыг зориулалтын бус газарт хаясан гэх зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна. (*Байгаль орчны хяналт 2025 | Месс, n.d.*)

2. Хяналт, шалгалтын арга хэмжээ

Экологийн цагдаагийн албанаас жил бүр “Ногоон бүсийн хяналт”, “Ойн хулгайн эсрэг шалгалт”, “Хууль бус олборлолт илрүүлэх хамтарсан рейд”, “Байгаль хамгаалалт зэрэг урьдчилан сэргийлэх шалгалтуудыг зохион байгуулдаг.

2024 онд улсын хэмжээнд 25,000 гаруй объект байгаль орчны хяналт шалгалтад хамрагдсан бөгөөд нийт 1,200 гаруй зөрчил илэрчээ. Цагдаагийн байгууллага, Байгаль орчны байцаагчид хамтран шинэ дрон, GPS, хиймэл дагуулын зураг ашиглан ойн нөөц, усны хамгаалалтын бүсийг хянаж эхэлсэн.

3. Иргэдийн оролцоотой урьдчилан сэргийлэлт

“Иргэн бүр хариуцлагатай байгаль хамгаалагч” аяны хүрээнд 2022–2024 онд 60 мянга гаруй иргэн, сурагч байгаль хамгаалах сургалтад хамрагдсан. Нутгийн иргэдийг нөхөрлөл, ТББ-ын түвшинд байгаль хамгаалалтын сайн дурын хяналт хийхэд дэмжлэг үзүүлж, “Ногоон паспорт” хөтөлбөрөөр хүүхэд, залуусын оролцоог нэмэгдүүлж байна.

4. Технологийн шинэчлэл ба инновац

Экологийн цагдаагийн албанаас “Эко мониторинг” нэртэй дижитал системийг 2023 онд туршиж, ой, ус, хог хаягдлын мэдээллийг цахим байдлаар бүртгэх, зөрчил илрүүлэх системийг нэвтрүүлээд байна. AI ба дрон ашиглан зөрчил илрүүлэх, усны чанарын хяналт хийх, хууль бус олборлолтыг автомат илрүүлэх туршилтыг 2024 оноос эхлүүлж,

2025 онд улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна..

Өнөөдөр хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх хэлбэрийг дараах байдлаар тодорхойлж байна. Тухайлбал:

1.Сурталчилгаа, танин мэдүүлэх хэлбэр

- Сургалт, лекц, мэдээллийн кампанит ажил, хэвлэл мэдээллээр дамжуулан хууль, дүрмийг таниулах,

- Байгаль орчны үнэ цэнийг ойлгуулах олон нийтийн аян (ж: “Нэг хүн – нэг мод”, “Цэвэр усны төлөө”).

2.Хууль сахиулах, хяналт шалгалтын хэлбэр

- Экологийн цагдаагийн алба, мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагчийн шалгалт,

- Хяналт-шалгалтын явцад зөрчлийг шууд таслан зогсоох, торгууль, хариуцлага ногдуулах.

3.Нийгэм-эдийн засгийн дэмжлэгийн хэлбэр

- Иргэдэд хууль ёсны, байгальд ээлтэй амьжиргааны эх үүсвэр бий болгох (ж: эко аялал жуулчлал, нөхөн сэргээх ажилд оролцуулах),

- Төрөөс санхүү, техникийн дэмжлэг үзүүлэх.

4.Хамтын ажиллагааны хэлбэр

- Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн санаачилгатай уялдуулан ажиллах,

- Олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналт, эргүүл (иргэдийн бүлэг, сайн дурын байгаль хамгаалагчид).

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн хуулийн арга хэмжээ авахад биш, сургалт, ухамсар, нийгэм-эдийн засгийн дэмжлэг, хамтын оролцоо гэсэн иж бүрэн системтэйгээр хэрэгжиж байж, үр дүнд хүрэх учиртай.

Улсын хэмжээнд 2022-2025 онд бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, гомдол, мэдээллийн нөхцөл байдлыг түүвэрлэн авч үзье.

Он	Гомдол, мэдээлэл	Шийдвэрлэлтийн төлөв	Өсөлт, бууралт
2022	Улсын хэмжээнд 2022 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2216 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 73 гомдол, мэдээллээр буюу 3.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Гэмт хэргийн шинжтэй 1210, зөрчлийн шинжтэй 980 гомдол, мэдээллийг буюу 98.8 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 26 буюу 1.2 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд байна. Үүнээс 25 буюу 96.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1 буюу 3.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.	3.4%-аар өссөн
2023	Улсын хэмжээнд 2023 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2223 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 7 буюу 0.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Гэмт хэргийн шинжтэй 1056, зөрчлийн шинжтэй 1124 гомдол, мэдээллийг буюу 98.1 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 43 буюу 1.9 хувь нь хуулийн хугацаанд шалгагдаж байна. Үүнээс 39 буюу 90.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4 буюу 9.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.	0,3%-аар өссөн.





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠨᠠᠭ ᠪᠠᠶᠠᠭᠠᠯ ᠨᠠᠭ ᠠᠵᠢᠭᠠᠨ ᠨᠠᠭ ᠠᠵᠢᠭᠠᠨ

2024	Улсын хэмжээнд 2024 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2399 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 176 буюу 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	Гэмт хэргийн шинжтэй 982, зөрчлийн шинжтэй 1389 гомдол, мэдээллийг буюу 98.8 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 28 буюу 1.2 хувь нь хуулийн хугацаанд шалгагдаж байна. Үүнээс 24 буюу 85.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4 буюу 14.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.	7,9%-аар өссөн
2025 /эхний 8 сарын байдлаар/	Улсын хэмжээнд 2025 оны эхний 08 сард хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1305 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс 290 буюу 18.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	Гэмт хэргийн шинжтэй 565, зөрчлийн шинжтэй 687 нийт 1252 гомдол, мэдээлэл буюу нийт 95.9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 53 буюу 4.1 хувь нь хуулийн хугацаанд шалгагдаж байна. Үүнээс 38 буюу 71.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 15 буюу 28.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.	18.1%-аар буурсан

Дээрх хүснэгтэд дурдсан статистик тоо мэдээнүүдээс үзвэл 2022-2024 он буюу өмнө 3 жилийн хугацаанд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо мэдээ байнга өсч ирсэн бол 2025 оны эхний 8 сарын байдлаар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсад байгаль орчны зөрчил сүүлийн таван жилд тогтвортой өсөлттэй, шинж чанарын хувьд хууль бус ашиглалт, бохирдол, хамгаалалтын бүсийн зөрчил давамгай хэвээр байна. Хэдийгээр төрийн байгууллагууд хяналт, мониторингийн тогтолцоог шинэчлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд ахиц гаргаж байгаа ч, урт хугацаанд хууль хэрэгжилтийг чангатгах, хохирлын нөхөн төлбөрийг эдийн засгийн хөшүүрэг болгох, боловсролын түвшинд байгаль хамгааллын ухамсрыг төлөвшүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Судалгааны хэсэг. Өнөөдрийн байдлаар цагдаагийн төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүд дээр хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хэрхэн явагдаж байгаа талаар ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны 24 экологийн байцаагч нараас анкет асуулгын аргаар судалгаа авч дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд оролцсогчдын насны байдлыг авч үзвэл 1 буюу 4.2% нь “18-25”, 3 буюу 12.5% нь “26-29”, 4 буюу 16.7% нь “30-34”, 10 буюу 41.7% нь “35-39”, 6 буюу 25% нь “40-44” насны алба хаагчид байсан бөгөөд хүйсний хувьд 100% “эрэгтэй” алба хаагчид хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан экологийн байцаагч нарын ажилласан жил, туршлагыг нь харвал, 11 буюу 45.8% нь “1-3 жил”, 9 буюу 37.5% нь “4-6 жил”, 1 буюу 4.2% нь “7-10 жил”, 2 буюу 8.3% нь “11-15 жил”, 1 буюу 4.2% нь “16-20 жил” ажилласан туршлагатай алба хаагчид оролцсон бөгөөд 19 буюу 79.2% нь хөдөө орон нутаг, 5 буюу 20.8% нь нийслэлд ажиллаж байгаа байцаагч нар хамрагджээ.



График №1. Зөрчлийн нөхцөл байдал

Судалгаанд оролцогчдоос “Таны ажиллаж байгаа нутаг дэвсгэрт байгаль орчны эсрэг зөрчил хэр их гардаг вэ?” гэсэн асуултыг тавихад 7 буюу 29% нь “Их”, 11 буюу 46% нь “дунд зэрэг”, 5 буюу 21% нь “бага”, 1 буюу 4% нь “гардаггүй” гэсэн хариултыг өгчээ. Түүнчлэн “Та сард дунджаар хэдэн гэмт хэрэг, зөрчил илрүүлдэг вэ?” гэсэн асуултад 16 буюу 70% нь “1-3”, 4 буюу 17% нь “4-6”, 1 буюу 4% нь “7-10”, 2 буюу 9% нь “11-15” гэмт хэрэг, зөрчил илрүүлдэг гэсэн байна.



График №2. Зөрчлийн

Энэ нь хөдөө, орон нутагт ажиллаж байгаа экологийн байцаагч нар хариуцсан нутаг дэвсгэртээ үйлдэгдэж байгаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлээд зохих хэмжээнд шийдвэрлэж байна гэж үзэж болохоор байна.

Хөдөө орон нутагт хүрээлэн буй орчны эсрэг ямар төрлийн гэмт хэрэг, зөрчил хамгийн их гардаг талаар тодруулахад дор дурдсан хүснэгтэд байгаа гэмт хэрэг, зөрчил гардаг талаар дурдсан байна.

№	Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалт	тоо	Эзлэх хувь
1.	7.2 дугаар зүйл.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих	1	4.2%
2.	7.4 дүгээр зүйл.Агаарын тухай хууль зөрчих	1	4.2%
3.	7.7 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль зөрчих	7	29.2%
4.	7.9 дүгээр зүйл.Ойн тухай хууль зөрчих	7	29.2%
5.	7.10 дугаар зүйл.Газрын хэвлийн тухай хууль зөрчих	3	12.5%
6.	7.11 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хууль зөрчих	2	8.3%
7.	7.16 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих	1	4.2%
8.	7.17 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах	1	4.2%
9.	Бүгд гарна	1	4.2%

Хүснэгт №1. Зөрчлийн гаралт

Дээрхи хүснэгтэд дурдсан зөрчлүүдээс “Байгалийн ургамлын тухай хууль зөрчих”, “Ойн тухай хууль зөрчих”, “Газрын хэвлийн тухай хууль зөрчих”, “Ашигт малтмалын тухай хууль зөрчих” гэсэн зөрчлүүд хамгийн их гардаг гэсэн байна. Энэ нь хууль бусаар мод бэлтгэх, зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлох гэсэн зөрчлүүд давамгайлдаг юм байна.



Дэвсгэрт байгаа нутаг дэвсгэрт байгаль орчны эсрэг зөрчил хэр их гардаг вэ?



МОНГОЛЫН ХҮҮЛЬ
САХИУЛАХ
МОНГОЛЫН
ХҮҮЛЬ
САХИУЛАХ



График №3. Зөрчлийн гаралт



График №4. ГХУСА-н зохион байгуулалт

Дээрхи графикаас үзвэл судалгаанд оролцсон экологийн цагдаагийн байцаагчдын 70 орчим хувь нь ажлын цагийнхаа 50-аас дээш хувийг хэрэг, зөрчлийн газар дээр ажиллахад зарцуулагддаг гэж хариулсан нь ачаалалтай ажилладаг болохыг харуулж байна.

Харин “Та өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ хэр зохион байгуулдаг вэ?” гэсэн асуултад 14 буюу 56% нь “их”, 8 буюу 32% нь “дунд зэрэг”, 3 буюу 12% нь “бага” гэсэн хариултыг тус тус хариулсан байна.

Энэхүү хариулт нь орон нутгийн экологийн байцаагч нар нь нутаг дэвсгэрийн онцлог, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил харилцан адилгүй зохион байгуулагддаг болохыг харуулж байна.



График №5. Хүндрэл бэрхшээл

“Танд хүрээлэн буй орчны эсрэг зөрчил шалгахад ямар хүндрэл учирдаг вэ?” гэсэн асуултад 15 буюу 61% нь “Тээврийн хэрэгсэл”, 5 буюу 22% нь “Компьютер, принтер болон бусад холбогдох техник хэрэгсэл дутмаг” гэсэн 2 хариултуудыг дийлэнхи оролцогчид хариулсан нь анхаарал татаж байна.



График №6. Төсөв хөрөнгө

“Таны ажиллаж байгаа цагдаагийн газар, хэлтсээс байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил, арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай төсөв, хөрөнгө гаргаж өгдөг үү?” гэсэн асуултад 8 буюу 33% нь “тийм” гэсэн бол үлдсэн 16 буюу 67% нь шаардлагатай төсөв хөрөнгийн талаар хангалтгүй гэсэн хариултыг өгчээ.

Энэ нь нутгийн захиргааны байгууллага буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх



График №7. Хамтын ажиллагаа

“Та байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахдаа орон нутаг, байгаль орчны улсын байцаагч нартай хэр их хамтарч ажилладаг вэ?” гэсэн асуултад 13 буюу 54% нь “байнга”, 9 буюу 38% нь “зармидаа”, 2 буюу 8% нь “зөвхөн хүсэлт тавьсан тохиолдолд” гэсэн хариултыг өгчээ.

Судалгаанд оролцогчид “Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн үү?” гэсэн асуултад 15 буюу 62% нь “тийм”, 5 буюу 21% нь “үгүй”, 1 буюу 4% нь “мэдэхгүй”, 3 буюу 8% нь “магадгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Дээрхи графикуудаас үзвэл орон нутгийн улсын байцаагч нартай хамтын

сангаас шаардлагатай хөрөнгөө авч чадахгүй байгаа гэж үзэж байна.




График №8. Эрх зүйн орчин

ажиллагаа харьцангуй сайн гэж үзэж болохоор байна. Харин хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах эрх зүйн орчныг 62% нь бүрдсэн гэж үзсэн бол үлдэг 38% нь “үгүй”, “мэдэхгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн нь экологийн байцаагч нарын эрх зүйн мэдлэг харилцан адилгүй байгаа төдийгүй сургалт хангалттай бус гэж үзэж болохоор байна.

“Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад танд ямар хүндрэл бэрхшээл учирдаг вэ?” гэсэн асуултад доорхи хүснэгтэд орсон хариултуудыг тус тус өгчээ.

№	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад танд ямар хүндрэл бэрхшээл учирдаг вэ?	Тоо	Эзлэх хувь
1.	Байнга хөдөө явах шаардлага тулгардаг	3	12.5%
2.	Урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад ашиглах албаны машин байхгүй	7	29.2%
3.	Шаардлагатай хөрөнгө, мөнгө хуваарилдаггүй	2	8.3%
4.	Нутгийн захиргааны байгууллагаас дэмжлэг туслалцаа үзүүлдэггүй	1	4.2%
5.	Орон тоо дутмаг	1	4.2%
6.	Гэмт хэрэг, зөрчил шалгаад урьдчилан сэргийлэх ажил явуулах зав гардаггүй	1	4.2%
7.	Шаардлагатай техник хэрэгсэл дутмаг /дрон, нөтбүүк, принтер г.м/	3	12.5%
8.	Урьдчилан сэргийлэх ажлыг ихэвчлэн хөдөө явж хийх шаардлага тулгардаг	2	8.3%



МОНГОЛЫН ХҮҮЛЬ



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

9.	Төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад ойлголцдоггүй, хүндрэл учирдаг	1	4.2%
10.	Ажлын байрны орчин нөхцөл хүнд	1	4.2%
11.	Хүндрэл байхгүй ч шаардлагатай техник хэрэгсэл дутмаг	1	4.2%

Хүснэгт №2. Хүндрэл бэрхшээл

Дээрхи хүндрэл бэрхшээлүүдээс хамгийн их нь гэр орноосоо хол байнга хөдөө явдаг, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах ажил явуулахад шаардлагатай машин, тээврийн хэрэгсэл байдаггүй, зарим газарт шаардлагатай техник хэрэгсэл дутмаг /дрон, нөтбүүк, принтер г.м/ дутмаг байгаа нь анхаарал татаж байна.



График №9. Үр дүн

Судалгаанд оролцогчид “Өнөөдрийн байдлаар таны хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж байгаа байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн хэр байдаг вэ?” асуултад 11 буюу 46% нь “сайн”, 11 буюу 46% нь “дунд зэрэг”, 2 буюу 8% нь “муу” гэсэн хариултыг тус тус өгчээ. Энэ нь 46% нь сайн гэсэн бол үлдсэн 54% нь хангалттай бус гэсэн

хариултыг өгсөн нь зохион байгуулсан ажил, арга хэмжээнийхээ үр дүнг тооцож, ажлаа төлөвлөж чадахгүй, жигд бус явуулдаг гэж үзэж болохоор байна.

“Байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хамгийн үр дүнтэй гэж үзэж буй ямар арга хэлбэр байдаг вэ?” гэсэн асуултад доорхи хүснэгтэд орсон хариултыг өгчээ.

№	Байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хамгийн үр дүнтэй гэж үзэж буй ямар арга хэлбэр байдаг вэ?	тоо	Эзлэх хувь
1.	Сургалт	1	4.2%
2.	Сурталчилгаа	2	8.3%
3.	Хяналт, шалгалт	5	20.8%
4.	Хамтын ажиллагаа	2	8.3%
5.	Шаардлагатай техник хэрэгслийн хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх	3	12.5%
6.	Иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх	7	29.2%
7.	Дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх	2	8.3%
8.	Сургалт сурталчилгаа, иргэдийн оролцоо	3	12.5%

Хүснэгт №3. Үр дүнтэй арга, хэлбэр

Дээрхи хүснэгтээс үзвэл судалгаанд оролцогчдын дийлэнх нь “иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах”, сургалт, сурталчилгааг

нэмэгдүүлэх”, “Шаардлагатай техник хэрэгслийн хангамж хүрэлцээг нэмэгдүүлэх” гэсэн аргуудыг үр дүнтэй гэж үзэж байна.



Судалгаанд оролцсон экологийн байцаагч нарт “Байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цаашид хөгжүүлэхийн тулд ямар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?” гэсэн асуултыг тавихад нэлээн олон хариулт өгснийг агуулгын хувьд дараах байдлаар нэгтгэв. Тухайлбал:

- Техник хэрэгсэл бензинээр хангах
- Сургалт сурталчилгаа иргэдийн

оролцоог нэмэгдүүлэх

- Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт тогтмолжуулах

- Үндсэн ажлын хажуугаар хэв журам, замын зөрчлүүд шалгуулдаг асуудлыг болиулах

- Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах

- Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах

- Цахимаар зөрчлийн материалыг харьяалалын дагуу шилжүүлдэг болох

- Дэвшилтэт техник технологи, зөөврийн компьютер, принтерээр хангах

- Зөрчил үйлдэгч нарт хүлээлгэх хариуцлага, хууль эрх зүйн орчныг чангатгах.

- Экологийн байцаагч нарт гүйцэтгэх ажлын эрх олгох гэсэн хариултыг тус тус өгчээ.

Харин “Байгаль орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэхийн тулд ямар хэлбэрийн ажил илүү үр дүнтэй гэж та боддог вэ?” гэсэн асуултад хөдөө орон нутгаар явж иргэдэд сургалт зохион байгуулах, ухуулга сурталчилгаа явуулах, хүн бүр байгаль орчинг хамгаалах гэсэн иргэдийн сэтгэхүйг суулгах, зорилтод бүлэг рүү чиглэсэн арга хэмжээг онцгойлон анхаарах, олон нийтийн сүлжээ ашиглан хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор аюулыг ойлгуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь үр дүнтэй гэж үзжээ.

“Байгаль орчны эсрэг зөрчилтэй тэмцэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хэрхэн сайжруулах боломжтой вэ?” гэсэн асуултад “Хөдөө орон нутагт дотроос нь төрийн албан хаагчийг

томиллохгүй байх”, “Төрийн хяналт шалгалт, болон санхүүжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх”, “Төрийн албан хаагч нарыг мэдээлэл задруулахгүй байх, мэдээ мэдээлэл тарааж бусдад давуу байдал бий болгох явдлаас урьдчилан сэргийлэх”, “хамтын удирдлагыг дээшлүүлэх”, “суманд байгаль орчны байцаагчтай болгох” зэрэг саналуудыг гаргасан байна.

Гадаадын зарим орны туршлага.

Гадаадын улс орнуудад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлсэн боловч Монгол Улсад хараахан хэрэгжээгүй 5 шинэ туршлагыг энэхүү хэсэгт авч үзлээ.

1. “AI Eco-Patrol” (*Smart Eco-Patrol*, n.d.)— Хиймэл оюунд суурилсан байгаль хамгаалалтын хяналтын систем (Сингапур). Энэхүү систем нь хиймэл оюун, дрон, мэдрэгч ашиглан хууль бус мод бэлтгэл, бохирдлыг автомат илрүүлдэг систем юм. Бодит цагийн өгөгдлийг төв серверт илгээж, цагдаа, байгаль орчны байцаагчид шуурхай мэдээлэл авдаг. Монгол Улсад дрон ашиглаж эхэлсэн ч AI хосолсон автомат хяналт бүрэн нэвтрээгүй.

2. “Green Crime Data Hub” (*Just a Moment...*, n.d.)— Байгаль орчны зөрчил бүртгэлийн нэгдсэн цахим сан (Финланд). Энэхүү сан нь байгаль орчны зөрчил, торгууль, хяналтын дүнг нэгдсэн онлайн платформуор бүртгэдэг. Иргэн, байгууллага зөрчлийн мэдээллийг нээлттэй харах боломжтой тул ил тод, хариуцлагатай хяналт бүрдсэн. Монголд зөрчлийн мэдээлэл тархай, нэгдсэн дата сан хараахан байхгүй байгаа нь энэхүү сангийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

3. “Circular Enforcement” (*Waste Management Regulations in the Netherlands*, n.d.)— Хог хаягдлын зөрчлийг дахин ашиглалтаар шийдвэрлэх бодлого (Нидерланд). Хог хаягдлын хууль бус хаягдлыг илрүүлбэл торгох бус, дахин боловсруулалт, нөхөн сэргээх ажилд оролцуулах байдлаар шийдвэрлэдэг. Энэ нь шийтгэлээс илүү сургалт, ухамсар нэмэгдүүлэх хэлбэрийн урьдчилан сэргийлэлт юм. Монголд ийм шийтгэл



ХУУЛЬ САХИУЛАХУЙ

болон сэргээн ашиглалтын хосолсон загвар урьд өмнө нь хэрэгжиж байгаагүй юм.

4. “Eco-Court” (About the Tribunal - Environmental Protection Tribunal of Canada, n.d.) — Байгаль орчны хэрэгт мэргэшсэн тусгай шүүх (Канад). Байгаль орчны гэмт хэрэг, зөрчлийг экологийн эрх зүйд мэргэшсэн шүүгчид шийдвэрлэдэг. Энэ тогтолцоо нь шүүхийн шатанд урьдчилан сэргийлэх, бодлого тодорхойлоход туслах үүрэгтэй. Монгол Улсад урьд өмнө байгаль орчны хэрэгт тусгай шүүх байгуулагдаагүй.

5. “Community Eco-Police” (警察庁-自主防犯ボランティア活動支援サイト, n.d.) — Иргэдийн сайн дурын байгаль хамгаалалтын цагдаа (Япон). Иргэдийг сургалтад хамруулж, экологийн сайн дурын хяналтын баг болгон ажиллуулдаг. Тэд хууль бус ан, мод бэлтгэл, бохирдлын талаарх мэдээллийг шуурхай илгээдэг. Монгол Улсад “ойн нөхөрлөл” байдаг ч хууль сахиулах чиг үүрэгтэй сайн дурын эколописын тогтолцоо алга.

Дээрхи 5 туршлага нь байгаль орчны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг технологи, иргэдийн оролцоо, тусгай институт, хариуцлагын шинэ загвараар шинэ шатанд гаргаж чадсан бөгөөд Монгол Улсад нэвтрүүлэх бүрэн боломжтой, шинэлэг санаачилгууд юм.

Дүгнэлт

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гардаг болох нь судалгаагаар харагдаж байгаа бөгөөд хамгийн гол нь ой модтой, байгалийн баялаг ихтэй, газрын ашигт малтмалтай газруудад түлхүү гардаг нь цагдаагийн байгууллагаас гаргадаг статистик тоо мэдээнээс харж болохоор байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын экологийн байцаагч нар нутгийн захиргааны байгууллага болон байгаль орчны улсын байцаагч нартай хамтран зохион байгуулдаг боловч нутаг дэвсгэрийн онцлог, экологийн байцаагчийн ажлын арга барил, туршлага, шаардлагатай

төсөв хөрөнгийн дутмаг байдал, шаардлагатай техник хэрэгслийн хангамж хүрэлцээ зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй зохион байгуулагддаг нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон экологийн байцаагч нар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд рүү чиглэсэн сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалгах, гарахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад шаардлагатай техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, экологийн байцаагч нарыг тээврийн хэрэгслээр хангах, шаардлагатай бензин хуваарилж байх, нутгийн захиргааны байгууллага болон байгаль орчны улсын байцаагч нартай харилцан хамтран ажиллах эрх зүйн орчныг сайжруулах зэрэг олон саналуудыг дэвшүүлж байгаа нь энэ чиглэлийн ажил дутмаг байгаа юм байна гэж үзэхэд хүргэж байна.

Гадаадын зарим орон, тэр дундаа Сингапур, Финланд, Нидерланд, Канад, Япон улсуудад нэвтрүүлж тодорхой үр дүнд хүрсэн туршлагуудыг Монгол Улсад тодорхой хугацаанд, тодорхой нутаг дэвсгэрт нэвтрүүлж, үр дүнг тооцох нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Санал

Бид өөрсдийн хийсэн судалгааны материал дээрээ тулгуурлан гаргасан дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Нутгийн захиргааны байгууллага болон тухайн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сантай хамтран экологийн байцаагч нарт машинтай болгох арга хэмжээ авах

2. Олон нийтийн цахим сүлжээ ашиглан хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан үе шаттай зохион байгуулах арга зүйн сургалтыг зохион байгуулах

3. Орон нутгийн иргэд, малчид руу чиглэсэн урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг түлхүү зохион байгуулж, экологийн сайн дурын хяналтын багийг

байгуулж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх

4. Хог хаягдлын хууль бус хаягдлыг илрүүлбэл торгох бус, дахин боловсруулалт, нөхөн сэргээх ажилд оролцуулах байдлаар шийдвэрлэдэг аргыг тодорхой хугацаанд нэвтрүүлж, үр дүнг тооцож үзэх

5. Байгаль орчны зөрчил, торгууль, хяналтын дүнг нэгдсэн онлайн платформуор бүртгэдэг сан байгуулж, иргэн, байгууллага зөрчлийн мэдээллийг нээлттэй харах боломжийг бий болж, ил тод, хариуцлагатай хяналт бүрдүүлэх зэрэг болно.

Ашигласан материалын жагсаалт

About the Tribunal - Environmental Protection Tribunal of Canada. (n.d.). Retrieved December 10, 2025, from https://www.eptc-tpec.gc.ca/en/about/about-eptc.html?utm_source=chatgpt.com

Just a moment... (n.d.). Retrieved December 10, 2025, from https://poliisi.fi/documents/25235045/28576016/Environmental-crime-report-2024.pdf/3967e657-f741-c932-af46-92e11f590179/Environmental-crime-report-2024.pdf?t=1762259086251&utm_source=chatgpt.com

Smart Eco-Patrol. (n.d.). Retrieved December 10, 2025, from https://cupola360.com/en/showcase_eco/?utm_source=chatgpt.com

Waste Management Regulations in the Netherlands. (n.d.). Retrieved December 10, 2025, from [https://www.maak-law.com/product-compliance-netherlands/waste-](https://www.maak-law.com/product-compliance-netherlands/waste-management-regulations-netherlands/?utm_source=chatgpt.com)

management-regulations-netherlands/?utm_source=chatgpt.com

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://legalinfo.mn/mn/detail/8935>

#БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ_2025 | МЕСС. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://mecc.gov.mn/mng/posts/baigal-orcny-xianalt-202589898>

ГАЗРЫН ТУХАЙ. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=216>

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695>

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

ОЙН ТУХАЙ. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12171>

цагдаагийн хурандаа Т.Баатар: хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил зөвхөн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулснаар үр дүнд хүрэхгүй. (n.d.). Retrieved December 10, 2025, from <https://police.gov.mn/a/5696>

警察庁-自主防犯ボランティア活動支援サイト. (n.d.). Retrieved December 10, 2025, from https://www.npa.go.jp/safetylife/seianki55/?utm_source=chatgpt.com



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ